Аудитыг 2022 оны 3 дугаар сарын 05 -аас 2022 оны 3 дугаар сарын 25 -ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2022 оны 3 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Засаг даргад хүргүүлэхээр төлөвлөн, Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа, аудитын менежер Г.Даваа нар хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Н.Болдбаатар гүйцэтгэв.

Сүхбаатар аймгийн Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 04-ны өдрийн 1/60 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Засаг даргын үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Бид төрийн албыг мэргэшсэн боловсон хүчин тэдний өөдрөг хүсэл тэмүүлэл дээр тулгуурлан монгол улсынхаа хөгжил дэвшилд манлайлан оролцоно.” гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж, бүх шатны байгууллагын ажлын уялдаа холбоог хангаж төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээг шуурхай чирэгдэлгүй байх нөхцөлийг бүрдүүлж, нийгмийн эргэх хариуцлагыг сайжруулна.
- Иргэдийг уйгуржин монгол бичиг сурах идэвх санаачилгыг өрнүүлэх.
- Алслагдсан сум, багийн иргэдэд үндсэн болон нарийн мэргэжлийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- Хүүхдийн хөгжил хамгааллын үйлчилгээг сайжруулах, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлнэ.
- Боловсрол, соёл спортын салбарын үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.
- Хүн амыг хөдөлгөөний хомсдолоос сэргийлж, нийтийн бие тамирыг бүх нийтийн хөдөлгөөн болгож, өрнүүлэх
- Монгол хүний удмын санг хамгаалах, Угийн бичиг хөтлөлтийг нэмэгдүүлнэ.
- Үндэсний соёлын үнэт зүйлс, биет болон биет бус өвийн хадгалалт хамгаалалтыг сайжруулна.
- Хөгжлийн бэрхшээлтэй, одой болон ахмад настанд үзүүлэх нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулна.

- Аюултай хог хаягдлыг менежментийг боловсронгуй болгох замаар хариуцлага, урамшууллын тогтолцоог бүрдүүлж хог хаягдал ангилан ялгах, дахин боловсруулах, эргүүлэн ашиглах байгальд хор багатай аргаар устгах менежментийг бий болгож, хүн амд ногоон хэрэглээний соёл, орчны эрүүл ахуй зөв дадлыг төлөвшүүлнэ.
- Аливаа улс төр, хоосон амлалт, хээл хахуулиас ангид байх, Хууль ёс, ёс зүйг эрхэмлэн сахигч, ёсчлон хэрэгжүүлэгч байх зарчмуудыг өдөр тутмын үйл ажиллагаандаа удирдлага болгон ажиллаж байна
- Төрийн үйлчилгээг ил тод, хүнд суртал, чирэгдэлгүй, шуурхай, шударгаар хүргэх, хариуцлагатай бүтээлч байх
- Малын шилжилт хөдөлгөөнийг хянах, мал, амьтан болон тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний мөрдөн мөшгөх тогтолцоог бий болгон мал, амьтны халдварт өвчнийг тандах, эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээг, зохион байгуулах, төлөвлөхөд шаардагдах мэдээллийн санг бүрдүүлэх
- Засгийн газрын 2018 оны 20-р тогтоолын дагуу Idi.nda.gov.mn буюу “Орон нутгийн хөгжлийн индекс тооцох цахим мэдээллийн систем”-д өөрийн сумын 2019 оны хөгжлийн индексийн тоон үзүүлэлтийг 2020.03.10 дотор шинэчлэн оруулах
- Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналтыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Засаг дарга нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Эрдэнэцагаан сумын Засаг даргын 2021 онд санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна. Эрдэнэцагаан сумын Засаг даргын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

3.4 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаар сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 6,742.1 сая төгрөгөөс 2.0 хувиар буюу 134.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 101.2 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 463.5 сая, эцсийн үлдэгдэл 385.2 сая төгрөг болж, 78.3 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Арилжааны банк дахь харилцах	28.7	7.4	-21.3
Төрийн сангийн харилцах	356.4	513.1	156.7
Дүн	385.2	520.5	135.4

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 520.5 сая төгрөгийн 513.1 сая төгрөг төрийн сангийн дансанд, 7.4 сая төгрөг арилжааны банкны дансанд байршиж байна.

Мөнгөн хөрөнгийн харилцах дансанд сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт, хүүгийн орлого 86.2, ОНХС-ийн төсөл арга хэмжээний санхүүжилт 308.1, төсөвт байгууллагуудын жилийн эцсийн харилцахын үлдэгдлийг нэгдсэн дансанд төвлөрүүлсэн 50.1, байгууллагын банканд дахь дансны үлдэгдэл 18.7, төлөвлөгөөнөөс давсан татварын болон татварын бус орлого 50.0 сая төгрөг тус тус үлдэгдлээр үлджээ.

Арилжааны банканд эмийн эргэлтийн сан 0.7 сая, Чоногол хөгжил ОНӨААТҮГ-ын харилцах дансны үлдэгдэл 7.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

- Ажилчдын цалинг нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд дутуу илэрхийлсэн. /ЭМТ-2.9 сая/
- Аж ахуйн нэгж байгууллагатай холбоотой худалдан авалт татварын цахим системд бүртгэгдээгүй, И баримтаар нотлогдохгүй байна. /ЕБС-10.1 сая, Чоногол хөгжил ОНӨААТҮГ-1.1 сая, ОНХС-410.3 сая/
- Төсөл арга хэмжээг төлөвлөхдөө төсөвт өртгийг хувааж шууд худалдан авалт хийхээр төлөвлөсөн. /ОНХС-57.5 сая/
- Иргэдийн саналаар дэмжигдээгүй төсөл арга хэмжээг ИТХ-аар батлуулж хэрэгжүүлсэн. /ОНХС-95.6 сая/

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 356.0 сая, эцсийн үлдэгдэл 374.3 сая төгрөг болж, 18.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Төлбөртэй үйлчилгээний авлага	34.3	26.3	-8.0
Зээлийн хүүгийн авлага	12.8	8.8	-4.0
Бусад авлага/ТӨҮГ/	14.3	84.5	70.2
Байгууллагаас авах авлага	1.0	0	-1.0
Зээлийн авлага	293.6	254.7	-38.9
Дүн	356.0	374.3	18.3

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай 158.7 сая төгрөгийн дараах авлага байна. Үүнд:

- СХС-ийн хугацаандаа төлөгдөөгүй болон зээлийн авлага 158.7 сая төгрөгийн дансны авлага байна.

Бусад авлагын хувьд ЭМДС-аас авах 63.4, ОНААТҮГ-ын халаалтын дулааны авлага 14.3 сая төгрөгийн авлагууд багтаж байна.

Аудитын илрүүлэлт:

- Сум хөгжүүлэх сангаас зээл авсан иргэд үндсэн төлөлт, хүүгийн төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлж, барагдуулаагүй байна. /СХС-22.0 сая/

3.5.3 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 268.3 сая, эцсийн үлдэгдэл 283.4 сая төгрөг болж, 15.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	4.1	23.7	19.6
Эм боох материал			-21.3
	30.2	8.9	
Бичиг хэргийн материал	1.0	2.7	1.7
Аж ахуйн материал	154.7	174.0	19.3
Сэлбэг хэрэгсэл	2.6	2.1	-0.5
Түлш тослох материал	6.6	1.8	-4.8
Барилга засвар	0.1	0.1	-
Хүнсний материал	0.7	1.8	1.1
Бусад хангамжийн материал	15.3	15.3	-
Мал амьтад	53.0	53.0	-
Дүн	268.3	283.4	15.1

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны 283.5 сая төгрөгийн үлдэгдэлд аж ахуй, эм боох, тусгай зориулалтын, бусад хангамжийн материал болон мал амьтдын үлдэгдэл гол нөлөөлж байна. Материалын үлдэгдлийн 20.8 хувийг ЗДТГ, 34.5 хувийг Ерөнхий боловсролын сургууль, 15.8 хувийг Хүүхдийн цэцэрлэг, 15.5 хувийг ЭМТ тус тус эзэлж байна.

Аудитын илрүүлэлт:

- Хоол хүнсний зардлаас хэмнэгдсэн төсөв нь төсвийн хэмнэлтэд тооцогдохгүй бөгөөд төсвийн нэгдсэн дансанд төвлөрүүлэлгүй, хүнсний материал нөөцөлсөн. /1-р цэцэрлэг-0.9 сая, ЭМТ-0.7 сая/

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгө дансны эхний үлдэгдэл 5,939.6 сая, эцсийн үлдэгдэл 5,984.2 сая төгрөг болж, 44.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж	3,720.6	3,720.6	-
Тээврийн хэрэгсэл	528.1	528.1	-
Машин тоног төхөөрөмж	712.4	764.8	52.4
Тавилга эд хогшил	387.9	363.6	-24.3
Зам, гүүрийн байгууламж	39.4	39.4	-
Түүх соёл, музей дурсгалт зүйл	46.9	47.4	0.5
Ном	13.1	20.0	6.9
Бусад үндсэн хөрөнгө	436.9	447.0	10.1
Программ хангамж	3.0	3.0	-
Бусад биет бус хөрөнгө	50.3	50.3	-
Дүн	5,939.6	5,984.2	45.6

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 33.8, үнэ төлбөргүй хандиваар 154.3, балансаас балансад шилжиж ирсэн 9.3, нийт 197.4 сая төгрөгөөр нэмэгдэж АИТХ-ын 2021 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 37 тоот тогтоолоор сумын ЗДТГ-ын 20.0 сая төгрөгийн 1 тээврийн хэрэгслийг дуудлага худалдаа хийж, 13.3 сая төгрөгийн 1 тээврийн хэрэгслийг акталсан байна. Мөн 4.0 сая төгрөгийн хөрөнгө актлагдаж, 1.7 сая төгрөгийн хөрөнгийг данс хооронд шилжүүлсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- Үндсэн хөрөнгийн дансанд хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, үлдэгдэл өртөггүй, хөрөнгө бүртгэлтэй байна. /1-р цэцэрлэг-76ш, 2-р цэцэрлэг-36ш, ЗДТГ -65ш, ИТХ-19ш, ЭМТ-140ш/

3.5.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 160.0 сая, эцсийн үлдэгдэл 124.1 сая төгрөг болж, 35.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -
Ажилчидтай холбоотой өглөг	18.9	1.9	-17.0
Байгууллагад төлөх өглөг	52.7	55.9	3.2
Хувь хүмүүст төлөх өглөг	1.1	1.1	-
Дансны өглөг ТӨҮГ	21.9	0.7	-21.2
Татварын өглөг/ТӨҮГ/		1.2	1.2
Бусад урьдчилж орсон орлого	65.4	63.3	-2.1
Нийт дүн	160.0	124.1	-35.9

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэл 124.1 сая төгрөг байна. Тухайлбал: Сургууль, цэцэрлэгийн халаалтын зардлын өр төлбөр 19.9 сая, ковид-19 цар тахал үүссэнтэй холбогдуулан ЗГ-аас усны зардалд олгох хөнгөлөлтийг буцаан олгоогүй 26.6 сая, Чоногол хөгжил ОНӨААТҮГ-т барилга шилжиж ирснийг орлогын аргаар бүртгэсэн 63.3 сая, татварын өр төлбөр 3.1 сая, нүүрсний өглөг 7.5 сая төгрөгийн өр төлбөртэй байна.

Аудитын илрүүлэлт:

Сүхбаатар аймгийн эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 2021 оны 07 сарын 02 өдрийн А/18 тогтоолоор дулааны үнэ тарифт өөрчлөлт орсноор түлш халаалтын өглөгтэй гарсан байна./ЕБС-14.6 сая/

3.5.6 ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 5,237.3 сая, эцсийн үлдэгдэл 5,318.8 сая төгрөг болж, 81.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 6. Засгийн газрын хувь оролцоо /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+/, бууралт /-/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/	2,641.3	2,641.3	-	49.6
Хуримтлагдсан үр дүн	897.2	978.7	81.5	18.4
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,698.8	1,698.8	-	32.0
Дүн	5,237.3	5,318.8	81.5	100

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 5,318.8 сая төгрөг болж 81.5 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.5.7 Орлогын данс

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 5,554.3 сая төгрөг болж, өмнөх оноос 567.6 сая төгрөг буюу 10.2 хувиар буурсан байна. Орлого буурахад үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 467.7 сая, орон нутгийн төсвийн санхүүжилт 1,019.7 сая төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн байна.

Тайлант онд улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг 2,559.7, орон нутгийн тогтмол зардлын санхүүжилт 507.5, ОНХС-аас 545.5, орон нутгийн төсвийн байгууллагын санхүүжих 199.7, ЭМД-аас 97.3, орон нутгийн төсвийн орлогоор 480.1, төсөвт байгууллагын өөрийн орлогоос 53.5, нэмэлт санхүүжилтийн орлого 308.3, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 259.8, борлуулалтын орлого 542.9 нийт 5,554.3 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Аудитын илрүүлэлт:

- Сум хөгжүүлэх сангаас зээл авсан иргэдийн гэрээний хугацаа дуусаж, зээлийн үндсэн төлөлт, хүүгийн төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлж, барагдуулаагүй. /СХС-69.5 сая/

3.5.8 Зардлын данс

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зарлага 4,903.5 сая төгрөг болж өмнөх оноос 508.4 сая төгрөг буюу 10.6 хувиар буурсан байна. Бараа үйлчилгээний бусад зардал 30.7 сая, урсгал шилжүүлэг 1,063.6 сая төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн байна.

Тайлант онд цалин хөлс нэмэгдэл урамшлын зардалд 2,582.7, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлд 331.7, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 328.4, хангамж, бараа материалын зардал 173.6, норматив зардалд 18.3, эд хогшил, урсгал засварын зардалд 48.5, томилот зочны зардалд 7.6, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд 515.9, бараа үйлчилгээний бусад зардалд 494.2, урсгал шилжүүлэгт 241.5 сая нийт 4,903.5 сая төгрөгийг зарцуулсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор Ковид-19 цар тахлын нөхцөлд төсвийг үр ашигтай зарцуулж, хэмнэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг баримтлалгүй төсвийг зарцуулсан. /1-р цэцэрлэг-5.7 сая, 2-р цэцэрлэг-3.0 сая, ЗДТГ-12.1 сая, ИТХ-6.1 сая /
- Сахилгын шийтгэлтэй ажилчдад үр дүнгийн урамшуулал олгосон. /ЭМТ-1.6 сая
- Нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд нэр бүхий ажилчны цалинг илүү тайлагнасан./ 2-р цэцэрлэг-1.1 сая, ЗДТГ-1.3 сая/
- Хөдөлмөрийн чадвар алдалтын акттай 1 ажилтны 1-12 сарын цалингаас ХХОАТ-ыг чөлөөлөлгүй тооцоноос илүү суутгасан. /ЕБС-0.4 сая, Чоногол-0.2 сая/

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн төвлөрүүлэн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 06 дугаар тогтоолд зааснаар сумын төсвийн татварын орлого 456.6 сая төгрөг, татварын бус орлогыг 75.0 сая төгрөгөөр баталж, 2021 оны 08 сарын 11-ний өдрийн 04 тогтоолоор тодотгол хийж нийт орлогыг 94.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж, гүйцэтгэлээр 479.2 сая төгрөгийн орлого төвлөрч, төлөвлөгөө 24.3 хувиар тасарсан байна.

Хүснэгт № 7 Төвлөрүүлэх орлого /САЯ ТӨГРӨГ/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Өсөлт бууралт
НИЙТ ОРЛОГО	633.5	479.2	-154.3
ТАТВАРЫН ОРЛОГО	416.1	388.1	-28.0
Хувь хүний орлогын албан татвар	70.0	84.3	14.3
Үйл ажиллагааны орлого	10.0	15.1	5.1
Хөрөнгийн орлого	40.0	53.4	13.4
Шууд бус орлого	20.0	15.8	-4.2
Хөрөнгийн албан татвар	287.1	224.7	-62.4
Бууны албан татвар	3.0	2.8	-0.2
Малын тоо толгойн албан татвар	284.1	221.9	-62.2
Бусад татвар (төлбөр, хураамж)	44.0	24.2	-19.8
Улсын тэмдэгтийн хураамж	5.0	3.7	-1.3
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	15.0	-	-15.0
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	8.0	1.8	-6.2
Газрын төлбөр	16.0	18.7	2.7
Байгалийн нөөц ашигласны төлбөр	15.0	54.9	39.9
Ус рашаан ашигласны төлбөр	10.0	7.8	-2.2
Байгалийн ургамал ашигласны төлбөр	5.0	47.1	42.1
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	217.4	91.1	-126.3
Хүү, торгуулийн орлого	35.0	34.3	-0.7
Нэр заагдаагүй бусад орлого	182.4	56.8	-125.6

Орон нутгийн татварын орлого 28.0 сая, татварын бус орлого 126.3 сая нийт 154.3 сая төгрөгөөр буурсан байна. Үүнд: Малын тоо толгойн албан татвар 62.2 сая, нэр

заагдаагүй бусад орлого 125.6 сая, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 15.0 сая, хог хаягдлын хураамж 6.2 сая төгрөгөөр тасарч хувь хүний орлогын албан татвар 14.3 сая, байгалийн ургамал ашигласны төлбөр 42.1 сая төгрөгөөр давж биелсэн байна. Орлого тасрахад ковид цар тахлын нөлөөгөөр Хил гааль хаалттай уул уурхай компани үйл ажиллагаа явуулаагүйн улмаас гэрээний үүргээ биелээгүй нь голлон нөлөөлсөн байна. Харин сумын нөөцийн өвсийг 22 иргэнээр бэлтгүүлснээр ургамал ашигласны төлбөр 42.0 сая төгрөгөөр давж биелэхэд нөлөөлсөн байна.

Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2021 онд татварын орлогыг 456.6 сая, татварын бус орлогыг 75.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүргүүлсэн төсвийн татварын орлогыг тодотголоор 83.6 сая, татварын бус орлогыг 10.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна. Үүнд: малын тоо толгойн татварыг 101.8 сая, бусад орлогыг 24.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж, хувь хүний орлогын албан татварыг 10.0 сая, орлогыг тодорхойлох боломжгүй иргэний орлогыг 15.0 сая, хог хаягдлын үйлчилгээний хураамжийг 2.0 сая төгрөгөөр бууруулж баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 7 хөтөлбөрт зориулан 4,938.3 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 3,800.2 сая төгрөгийг урсгал зардалд, 997.8 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, сум хөгжүүлэх сангийн зээлд 140.3 сая төгрөгийг зарцуулахаар баталжээ.

Нийт зардлын 157.5 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс, 100.0 сая төгрөгийг сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс, 1,506.8 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 2,559.7 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 68.8 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалаас, 545.5 сая төгрөгийг ОНХС-аас олгох орлогын шилжүүлгээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр сум хөгжүүлэх сан 79.6, туслах үйл ажиллагааны орлогоос 0.1, орон нутгийн төсвөөс 1,110.0, тусгай зориулалтын шилжүүлгээс 2,492.8, эрүүл мэндийн даатгалын сангаас 34.6, ОНХС-д олгох орлогын шилжүүлэг 722.8 сая нийт 4,439.9 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, 498.4 сая төгрөгөөр хөтөлбөр арга хэмжээ дутуу санхүүжигдсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,439.9 сая төгрөг буюу 89.9 хувьтай байгаа нь орон нутгийн төсвөөс дутуу санхүүжүүлсэнтэй холбоотой байна.

Нэмэлт төсөв: Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж 4.7, ЗГНХ, ЗДНХөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 47.7, дээд шатны төсвийн захирагчаас 243.6, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 26.9 сая нийт 322.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс Цалин, НДШ-ын зардалд 119.8, хангамжийн бараа материал 1.5, норматив зардал 56.4, эд хогшил, урсгал засварын зардалд 0.3, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 22.3, бараа ажил үйлчилгээний бусад зардалд 41.4, урсгал шилжүүлэг 68.5 сая нийт 310.2 сая төгрөгийг зарцуулж, 12.7 сая төгрөгийг харилцахын үлдэгдэлтэй байна.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд 2 мэдээллийг мэдээлээгүй, 54 мэдээллийг хугацаанд нь, 41 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Харин таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 52 зарлагын гүйлгээний 1,259.4 сая, урсгал санхүүжилтийн 18 гүйлгээний 593.1 сая төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй байна.

Аудитын илрүүлэлт:

Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудаст мэдээллийг ил тод байршуулахаас мэдээллийг ил тод байршуулаагүй, мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. /1-р цэцэрлэг, 2-р цэцэрлэг, ЗДТГ, ИТХ, ЭМТ, ЕБС, Чоногол хөгжил ОНӨААТҮГ/

3.8. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 2 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	-	2	-	-	-	75
Нийт	2	-	2	-	-	-	75

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 7 төсвийн байгууллага, 1 ОНӨААТҮГ, 2 орон нутгийн тусгайн сангийн нийт 10 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 5 байгууллагад дүгнэлт гаргаж, 6 байгууллага түүврээр хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын 5 санхүүгийн тайланд “Зөрчилгүй” дүгнэлт өгөв.

Аудитаар нийт 5,505.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 5,443.3 сая төгрөгийн 19 алдааг аудитын явцад залруулж, 62.2 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 2 зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмжийг хүргүүлэв.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн байна. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайланд 7.5 сая төгрөгөөр мөнгөн хөрөнгийг илүү, 0.1 сая төгрөгөөр авлагыг илүү, 244.2 сая төгрөгөөр засгийн газрын оруулсан капиталыг дутуу, 7.6 сая төгрөгөөр хуримтлагдсан үр дүнг илүү нэгтгэсэн;
- Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд 1,176.3 сая төгрөгөөр санхүүжилтийн орлого илүү, 2.7 сая төгрөгөөр татварын ба татварын бус орлогыг илүү, 5.6 сая төгрөгөөр хангамж, бараа материалын зардлыг дутуу, 1.0 сая төгрөгөөр бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг илүү, 6.7 сая төгрөгөөр бараа үйлчилгээний бусад зардлыг дутуу, 1,177.1 сая төгрөгөөр урсгал шилжүүлгийн зардлыг илүү нэгтгэсэн;

- Нэгтгэсэн цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлтийн тайланд 7.6 сая төгрөгөөр тайлант үеийн үр дүнг дутуу нэгтгэсэн;
- Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайланд 1,215.2 сая төгрөгөөр санхүүжилтийн орлого илүү, 6.7 сая төгрөгөөр бараа үйлчилгээний бусад зардлыг дутуу, 1,214.3 сая төгрөгөөр урсгал шилжүүлгийн зардлыг илүү, 7.5 сая төгрөгөөр харилцах дансны үлдэгдлийг дутуу нэгтгэсэн;
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд 239.5 сая төгрөгөөр санхүүжилтийн орлого илүү, 121.4 сая төгрөгөөр орон нутгийн төсвийн орлогыг дутуу, 1.1 сая төгрөгөөр төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогыг дутуу, 1.1 сая төгрөгөөр цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг илүү, 0.1 сая төгрөгөөр урсгал шилжүүлэг зардлыг дутуу нэгтгэсэн;

Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага

Малын тоо толгойн албан татвар 62.2 сая төгрөгийн орлогыг дутуу төвлөрүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 41 дугаар зүйлийн 41.2.1 /хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх/-т заасан заалттай нийцэхгүй, тайлант хугацааны эцэс дэх дансны үлдэгдэл, холбогдох тодруулгатай холбоотой батламж мэдэгдлийн оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт тогтоох

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд 2 мэдээллийг мэдээлээгүй, 54 мэдээллийг хугацаанд нь, 41 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Харин таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 52 зарлагын гүйлгээний 1,259.4 сая, урсгал санхүүжилтийн 18 гүйлгээний 593.1 сая төгрөгийг гүйлгээг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 / тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;/ 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3, 6.4 дэх заалт болон ажил гүйлгээний анги, үйл явдал, холбогдох тодруулгын иж бүрэн байх, толилуулга, тасалбар болголт батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага

Төвлөрүүлсэн захирагчид алдаа, зөрчилд өгсөн 2 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 2,423.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 86.3 сая төгрөгийн 2 алдааг аудитын явцад залруулж, 73.9 сая төгрөгийн 8 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 628.6 сая төгрөгийн 16 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1,634.5 сая төгрөгийн 11 зөвлөмжийг хүргүүллээ.

3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх дараах анхаарал татахуйц асуудал байна.

Тухайлбал:

- Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар биологийн хөрөнгө болох мал амьтадыг бодит үнэ цэнийн аргаар санхүүгийн тайланд толилуулах,
- ОНХС-аар хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлуудыг ЗДТГ-т бүртгэх бус тус санд нь захиалагчийн зүгээс бүртгэж байгаа байдлыг хамруулан авч үзэхээр төлөвлөж байна.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

4.1 Данс бүртгэлтэй холбоотой асуудал:

4.1.1 Илрүүлэлт:

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагууд мал амьтадын нас дэвшилт болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг данс бүртгэлд бодит үнэ цэнийн аргаар толилуулаагүй нийтлэг алдаа гарсан байна.

4.1.2 Эрсдэл: НББ-ийн тухай хууль зөрчигдөх, Санхүүгийн нэгтгэсэн тайлан буруу илэрхийлэгдэх, Санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, оршин байх батламж мэдэгдэл зөрчигдөх

4.1.3 Өгсөн зөвлөмж:

Байгууллагуудын бүртгэлийг сайжруулж, дараагийн тайлангийн нэгтгэлийг хийхдээ Сангийн сайдын 2016 оны 12 сарын 16-ны өдрийн “Стандарт батлах тухай” 411 тоот тушаалын 1 дүгээр хавсралт “Биологийн хөрөнгө ба түүнээс хүлээн авсан хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нягтлан бодох бүртгэлийн стандарт”-ын дагуу биологийн болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бүртгэлийг иж бүрэн нэвтрүүлж, алдааг байгууллага бүр дээр залруулж, төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах

4.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн.

4.2.1 Илрүүлэлт:

Сумын орон нутгийн хөгжлийн сан болон эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл арга хэмжээний зардлыг бүртгэхдээ тухайн сангуудын санхүүгийн байдлын тайлангийн дуусаагүй үйлдвэрлэл дансанд төсөл арга хэмжээ тус бүрээр дэд данс нээж холбогдох зардлыг хуримтлуулан бүртгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.3.3 /дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх/ заалттай нийцэхгүй байна.

4.2.2 Эрсдэл

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний зардлыг дуусаагүй үйлдвэрлэл дансанд төсөл арга хэмжээ тус бүрээр дэд дансанд хуримтлуулан бүртгээгүйн улмаас нягтлан бодох бүртгэлийн хяналтын үр нөлөөг бууруулах эрсдэлтэй байна.

4.2.3 Өгсөн зөвлөмж

Сумын орон нутгийн хөгжлийн сан болон эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл арга хэмжээний зардлыг бүртгэхдээ тухайн сангуудын санхүүгийн байдлын тайлангийн дуусаагүй үйлдвэрлэл дансанд төсөл арга хэмжээ тус бүрээр дэд данс нээж холбогдох зардлыг хуримтлуулан бүртгэх.

4.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2021	Аудитын нэр:	Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан	Аудитын код: 2022/13/НА-СТА-ТТЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Засаг дарга		Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөн гөн дүн	Аудитын байгууллагаа с гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	Малын тоо толгойн албан татварын орлогыг дутуу төвлөрүүлсэн	62.2	Төлбөрийн акт	Засаг дарга Санхүү албаны дарга	Г.Эрдэнэчулуун Х.Шинэцэцэг
2	Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд 2 мэдээллийг мэдээлээгүй, 54 мэдээллийг хугацаанд нь, 41 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.	-	Албан шаардлага	Засаг дарга Санхүү албаны дарга	Г.Эрдэнэчулуун Х.Шинэцэцэг
3	Байгууллагын мал амьтадын нас дэвшилт болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг данс бүртгэлд бүртгэж тайлагнаагүй байна.	-	Зөвлөмж	Засаг дарга Санхүү албаны дарга	Г.Эрдэнэчулуун Х.Шинэцэцэг
4	Сумын орон нутгийн хөгжлийн сан болон эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл арга хэмжээний зардлыг бүртгэхдээ тухайн сангуудын санхүүгийн байдлын тайлангийн дуусаагүй үйлдвэрлэл дансанд төсөл арга хэмжээ тус бүрээр дэд данс нээж холбогдох зардлыг хуримтлуулан бүртгээгүй байна	-	Зөвлөмж	Засаг дарга Санхүү албаны дарга	Г.Эрдэнэчулуун Х.Шинэцэцэг
	Дүн	62.2			